

Мэдэгдэл

Огноо: 2018 оны 5-р сарын 11

Хэнд: Ерөнхий эрх мэдэлтэн, туслах бүлгийн
ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл;
бүсийн дал; гадас, номлол, дүүргийн
ерөнхийлөгч; бишоп, салбарын
ерөнхийлөгч; ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл; гадас,
тойргийн Халамжийн нийгэмлэг; Залуу эрэгтэйчүүдийн болон Залуу
эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Хэнээс: Санваарын болон Гэр бүлийн хэлтэс (801-240-2134)

Мэдэгдлийн утга: Мэдэгдэл, 2018 оны 4-р сарын 11: Хүчирхэгжсэн Мелкизедек санваарын
чуулга, Халамжийн нийгэмлэгтэй хамт тохинуулах талаар түгээмэл
асуудаг нэмэлт асуултууд

Тэргүүн Зөвлөлийн 2018 оны 4-р сарын 2-ны өдрийн “Хүчирхэгжсэн Мелкизедек санваарын чуулга, Халамжийн нийгэмлэгтэй хамт тохинуулах нь” захидлын хавсралтад 2018 оны 04-р сарын Ерөнхий чуулган дээр зарласан өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхэд тус болох хэд хэдэн асуулт, хариултыг оруулсан байна.

Нэмэлт асуултуудын хариултыг уг мэдэгдэлд оруулав. Мөн эдгээр түгээмэл асуудаг асуулт болон үүний хариултыг ministering.lds.org вэб хуудсанд байршуулсан.

Хүчирхэгжсэн Мелкизедек санваарын чуулга, Халамжийн нийгэмлэгтэй хамт тохинуулах нь

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Түгээмэл асуудаг

нэмэлт асуултууд, 2018 оны 05-р сарын 11

Чуулгууд ба Халамжийн нийгэмлэг

1. Ахлагчдын чуулга болон Халамжийн нийгэмлэгт анхаарал төвлөрүүлж байгаа нь бишопын болон тойргийн зөвлөлийн үүргийг бэхжүүлэх үү?

Тийм. Бишоп нь тэргүүлэх дээд прист бөгөөд “тойргийнхоо бусад удирдагчдад удирдамж, зөвлөгөө өгдөг” (*Гарын авлага 1, 2.1.1*). Тэрбээр тохинуулах даалгавар бүрийг хянаж баталдаг. Бишопын удирдлаган доор тойргийн зөвлөл нь “гишүүд гэрчлэлтэй болох, авралын ёслолуудыг хүлээн авах, гэрээнүүдийг сахих, Есүс Христийн ариуссан дагалдагчид болоход нь хүмүүст [туслах]” (*Гарын авлага 2, 4.4*) үндсэн үүрэг хариуцлагаа үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Тойргийн зөвлөлийн гишүүд болох ерөнхийлөгчид нь тус тус төлөөлдөг хүчирхэгжсэн ахлагчдын чуулга болон Халамжийн нийгэмлэг нь тухайн зөвлөлийн үр бүтээлтэй үйл ажиллагааг бэхжүүлдэг юм.

2. Ариун сүмийн болон номлолын мөн номлогчийг бэлтгэх төвийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд ямар чуулгад харьяалагддаг вэ?

Эдгээр ах өөрсдийн тойргийн ахлагчдын чуулгын гишүүд байдаг.

3. Гадасны түвшинд салбарын ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчилж буй дээд пристүүд дээд пристүүдийн чуулгын гишүүд мөн үү?

Үгүй. Гадасны салбарын ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчилж байгаа дээд пристүүд нь дээд пристүүдийн чуулгын гишүүд биш. Дээд пристүүдийн чуулгын гишүүд зөвхөн гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, бишопын зөвлөл, дээд зөвлөл зэрэг дээд прист байх шаардлагатай дуудлагатай байдаг бөгөөд үйлчилж буй патриарх ч бас энэ чуулгын гишүүн юм.

4. Бишопын зөвлөлд (тухайлбал, ганц бие залуучуудын гадсанд) үйлчилж байгаа ахлагчид дээд пристүүдийн чуулгын гишүүд мөн үү?

Үгүй. Бишопын зөвлөлд үйлчилж байгаа ахлагчид дээд пристүүдийн чуулгын гишүүд биш болно.

5. Ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд нь улирал тутмын тохинууллын талаар ярилцлага хийхээс гадна чуулгын гишүүдийнхээр айлчилж эсвэл тэдэнтэй жилд доод тал нь нэг удаа ярилцлага хийдэг байх ёстой юу? (Гарын авлага 2, 7.3.2-ыг үзнэ үү)

Тийм. Ерөнхий үүрэг хариуцлагынхаа хүрээнд ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл нь санваарын үүрэг хариуцлагатай холбоотой ярилцлагыг чуулгын гишүүдтэй хийдэг байвал зохино. Үүнд тухайн санваартны болон түүний эхнэр, гэр бүлийнх нь байдлын талаар жилд доод тал нь нэг удаа ярилцлага хийсэн байна. Ийм ярилцлагыг тухайн жилийн туршид хийсэн байж болно. Энэ ярилцлагыг хамтрагчтайгаа хамт хийдэг тохинуулах ярилцлагатай нэгтгэн холбож болохгүй.

6. Авралын ажлыг гүйцэлдүүлэхэд нь ахлагчдын чуулгын болон Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөлд хэн тусалж болох вэ?

Ахлагчдын чуулга ба Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн тухайн ажлыг шаардлагын дагуу хэрэгжүүлэхэд гишүүдийг зохион байгуулж болно. Жишээлбэл, үйлчлэл, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил, сайн мэдээг хуваалцах, халамж зэрэг ажлыг удирдаж, туслалцаа үзүүлэхэд гишүүдийг дуудаж болно.

7. Тойрогт нэгээс илүү ахлагчдын чуулга эсвэл Халамжийн нийгэмлэг байж болох уу?

Болно. Сургаал ба Гэрээ 107:89-д дурдсанаар тойргийн идэвхтэй Мелкизедек санваартны тоо ердийнхөөс олон байгаа тохиолдолд удирдагчид нэгээс илүү ахлагчдын чуулгыг зохион байгуулж болно. Энэ тохиолдолд чуулга бүр нас, туршлага, санваарын алба, хүч чадлын хувьд аль болох тэнцвэртэй байх ёстой. Халамжийн нийгэмлэгийн хувьд ижил зарчим баримтална.

Тохинуулах нь

8. Дээд пристийн чуулгын гишүүд тохинуулахад хэрхэн холбогдох вэ?

Бишопынхоо удирдлаган доор тухайн тойргийн тэргүүлэх дээд прист болон дээд пристүүдийн чуулгын гишүүд, тэдгээрийн гэр бүл ахлагчдын чуулга, Халамжийн нийгэмлэгээс томилогдсон тохинуулах ах, эгч нартай байдаг.

Гадасны ерөнхийлөгчийн болон бишопын зөвлөлүүд тухайн гадас эсвэл тойргийн бүх гишүүнийг хариуцдаг учраас энэ ах нарыг тодорхой хувь хүмүүс эсвэл гэр бүлүүдэд тохинуулахаар томилдоггүй. Дээд зөвлөлийн гишүүд болон үйлчилж буй патриархуудыг томилохыг тухайн орон нутгийн нөхцөл байдлаас шалтгаалан гадасны ерөнхийлөгч шийднэ. Хэрэв тэд томилогдохоор байгаа бол тойргийнх нь бишопын удирдлаган доор ахлагчдын чуулгын ерөнхийлөгч нь томилно.

Бишоп нь тэргүүлэх дээд прист, Израиль дахь олон нийтийн шүүгч зэрэг бусад чухал үүрэг хариуцлагаас гадна зөвлөхүүдийнхээ хамт өсвөр үеийнхнийг халамжлах онцгой үүрэг хариуцлагатай. Сургаал ба Гэрээ 107:15-д “Бишопын зөвлөл бол [Аароны]

санваарын ерөнхийлөгчийн зөвлөл бөгөөд үүний түлхүүрүүд буюу эрх мэдлийг атгадаг” гэсэн байдаг. *Гарын авлага I, 2.2*-т зааснаар “Бишопын зөвлөлийн гишүүд тойргийнхоо залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдэд анхаарал тавьж, дэмжиж тусална” гэжээ.

Түүнчлэн гадасны ерөнхийлөгч нь гадсан дахь тэргүүлэх дээд пристийн хувьд “гадасны анхдагч сүнслэг удирдагч нь” (*Гарын авлага I, 1.1.1*) ба “авралын ажлыг тэргүүлнэ” (*Гарын авлага I, 1.1.2*).

9. Ахлагчдын чуулга болон Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчид нь тохинуулах ажилд туслуулахаар нэмэлт зөвлөхүүдийг дуудаж болох уу?

Болохгүй. Ерөнхийлөгч хоёр зөвлөхтэй байдаг. Хэрэв удирдагчид нэмэлт туслалцаа хэрэгтэй гэж үзвэл, тохинууллын нэг эсвэл түүнээс олон нарийн бичгийн дуудлага өгөх талаар бишоптойгоо зөвлөлдөж болно. Эдгээр тохинууллын нарийн бичгүүдийг, жишээлбэл, тохинууллын ярилцлагын хуваарь гаргах, хийсэн ярилцлагын улирал тутмын тайлан боловсруулах ажилд томилж болно.

10. Тохинууллын зохицуулагч, хянагчид ямар үүрэгтэй вэ?

Тохинууллын зохицуулагч ба тохинууллын хянагч гэсэн дуудлагууд цаашид байхаа больж байна. Эдгээр албанд дуудлагатай байсан хүмүүс чөлөөлөгдөнө.

11. Тохинууллын ярилцлагыг хэн хийдэг вэ?

Ахлагчдын чуулгын болон Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн бүр нь тохинууллын ярилцлагыг хийнэ. Том тойрогт ч гэсэн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн бүр долоо хоног тутамд хэд хэдэн ярилцлага хийгээд байвал эдгээр ярилцлагыг хийх боломжтой гэдгийг удирдагчид мэдэж авах болно. Тохинууллын ярилцлагуудыг үр бүтээлтэй байлгахын тулд урт сунжруу байлгах шаардлагагүй.

12. Удирдагчид тохинууллын ярилцлагыг улирлын явцад хэзээ хийдэг байвал зохих вэ?

Тохинууллын ярилцлагуудыг улирлын *тури* хийж болох ба хийдэг байх ч ёстой бөгөөд улирлын сүүлийн долоо хоногт эсвэл сүүлийн сард хийхээр хойш тавьж болохгүй. Удирдагчид ярилцлагыг тогтмол хийснээр тохинууллын сүнслэг болон материаллаг зорилтуудад хүрч чадна гэдгийг ойлгох болно.

Тохинуулалд өсвөр үеийнхнийг татан оролцуулах

13. Залуу эрэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүдийг насанд хүрсэн хамтрагчтай тохинуулахаар томилж болох уу?

Тийм. Сүүлийн үед гарсан “Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ авах нь” гэх баримтанд тусгасан удирдамжинд тохинууллын хамтралд өсвөр үеийнхнийг насанд хүрэгчидтэй хамтрагч болгосноор бүрдүүлж болно гэж заажээ.

Тухайн удирдамжинд зааснаар “тохинууллыг” ямар нэгэн “үйл ажиллагаа” эсвэл “хичээл” гэж үзэж болохгүй гэсэн байна.

Удирдагчид өсвөр үеийнхнийг тохинууллын хамтрагчаар томилохдоо сүнсний өдөөлтөд үндэслэн шийдвэр гаргах ёстой. Насанд хүрсэн хамтрагчид үл ойлголцолд хүргэж болзошгүй нөхцөл байдлуудаас зайлсхийх ёстой. Хоёулхнаа үлдэх нөхцөлд болгоомжтой хандах ёстой бөгөөд ингэснээр өсвөр үеийнхэн тохинууллын аюулгүй болон амжилттай туршлагатай болно. Мөн өсвөр үеийнхнийг хүнд хэцүү нөхцөл байдалтай гэр орон, гэр бүлүүдэд томилохгүй байх мэргэн ухааныг ашигладаг байвал зохино.

14. Бүх Миа Мэйд болон Лоорел нар тохинуулах ажилд томилогдох ёстой юу?

Миа Мэйд болон Лоорел нарыг тохинууллын ажилд урьж оролцуулж болно. Эцэг эхчүүд болон удирдагчид залуу эмэгтэй болгонтой уулзаж зөвлөлдөх ёстой ба хэрвээ тэр үйлчлэл хийх боломжтой бөгөөд хүсэл зоригтой байгаа бол түүнийг тохинууллын ажилд томилж болно. Залуу эмэгтэйчүүд Халамжийн нийгэмлэгийн эгч нарын хамтрагч байна.

15. Өсвөр үеийнхэнд хэн тохинууллын даалгавар өгдөг вэ?

Бишопын зөвшөөрч баталснаар Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь Миа Мэйд болон Лоорел нарт тохинууллын даалгавар өгдөг. Мөн бишопын зөвшөөрлөөр ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн багш болон пристүүдэд тохинууллын даалгавар өгнө.